

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ,
ҮР ДҮНГ УРАМШУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.06.06

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хэрэгжилт	Хувь
1	Албан хаагчдын ажиллах таатай, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ажлын багаж, техник хэрэгсэл, материаллаг баазаар хангах.	1. Албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцлийг хангаж ажиллах	Албан хаагчдын ажиллах орчныг сайжруулахад жил бүр анхаарч, шат дараалалтай, төсвийн нөхцөл байдалтай уялдуулан шийдвэрлэж ажилласны үр дүнд ширээ сандал, техник тоног төхөөрмжийн хүрэлцээ хангамж сайжирсан. 8 компьютер, 2 зөөврийн компьютер, 5 принтертэй ажиллаж байна. Албан хаагчдаас авсан ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаанд шинэ байртай болох, канонтой болох, хуучин компьютер шинэчлэх, архивын өрөөтэй болох гэсэн санал гарсан. Үзэсгэлэн, сургалт, явуулын өдөрлөг зэрэг арга хэмжээнд ашиглах 2 асараар хангагдсан.	100
		2. Байгаль хамгаалагч нарыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрмжөөр хангах	Шивээговь сумын байгаль хамгаалагч 2021 онд мотоцикл, 3 байгаль хамгаалагчид болон албан хаагчдыг ажлын нимгэн ажлын хувцастай болгосон.	100
		3. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчдыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Байгаль хамгаалагчдыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчдыг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх. 2022 онд байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах, хууль бус ан, агнуураас урьдчилан сэргийлэх хавар, намрын ээлжит эргүүл шалгалтын ажлыг Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2 удаа зохион байгуулж, газар дээр нь зөрчлийг арилгуулж ажилласан.	100
		4. Албан хаагчдад хоол унааны нэмэгдэл олгох	2022 онд 12 орон тоо батлагдсан ч 9 орон тоотой ажиллаж байна. 2022 оны 6 сарын 06-ны байдлаар хоол, унааны мөнгө 1,378.0 мян.төг олгосон. Албан хаагчдын цалин, бусад нэмэгдэл, урамшуулал олгосон шийдвэр, мэдээллийг тухай бүр Шилэн данс, цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	100
2	Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалан боловсон хүчнийг мэргэшүүлэх, боловсролыг дээшлүүлэх, урамшуулах	1. Гадаад, дотоодын сургалт, зорилтот арга хэмжээнд хамруулах	Дотоод сургалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу 10 удаа 14 сэдвээр сургалт зохион байгуулж, тэмцээн, ярилцлага зэрэг олон хэлбэрээр явуулсан нь сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлсөн. Дотоод сургалтаас гадна БОАЖЯ, аймгийн ЗДТГ, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, ЗГХЭГ болон бусад байгууллагаас орон нутагт зохион байгуулсан 11 удаагийн танхимын болон цахим сургалтанд 9 албан хаагчид бүрэн хамрагдсан. Ёс зүйн дүрмээ хэн сайн мэдэх вэ? тест авч, албан хаагчдыг мэдлэгийг бататгасан нь үр дүнтэй болсон. Сургалтуудын үр дүнд ажлын бүтээмж нэмэгдэж, харилцаа, хандлагад эерэг нөлөө үзүүлсэн. Сургалтанд явсан томилолтын зардал 207.0	100

		мян.төг		
		2. Байгууллагын дотоод сургалтын үр дүнг сайжруулах, үр дүнг тооцож хэвшүүлэх	Байгууллагын дотоод сургалтын үр дүнг сайжруулахаар албан хаагч бүр санаачилга гарган ажиллаж байна. Тэмцээн, гарын авлага, тэмцээн, ярилцлага зэрэг арга хэлбэр ашиглаж явуулж, салбарын болон төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх мэдлэг, мэдээлэлтэй болсон.	100
		3. Албан хаагчийн цалин, зэрэг дэвийн нэмэгдэл, бусад хуульд заасан нэмэгдлийг Төрийн албаны хууль, холбогдох журам, шийдвэрийн дагуу олгох /Ур чадвар, зэрэг дэв, Төрийн алба хаасан хугцааны нэмэгдэл, хоол, унаа болон бусад /	МУ-ын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээ болон бусад холбогдох хууль, журамыг баримтлан албан хаагчдад олговол зохих цалин хөлс, нэмэгдэлийг бүрэн олгож байна. 2022 оны эхний таван сарын байдлаар: <ul style="list-style-type: none"> • Нийт 9 албан хаагчдын үндсэн цалинд 29,989.8 мян.төгрөг • 6 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 4 албан хаагч зэрэг дэвийн нэмэгдэл, 3 албан хаагч ур чадварын нэмэгдэл, 1 албан хаагч эрх бүхий албан тушаалтаны нэмэгдэл, 1 албан хаагч урамшуулал авсан бөгөөд нийт 9,301.3 мян.төгрөг зарцуулсан. • 9 албан хаагчид 1,378.0 мян.төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон. • Нийтлэг үйлчилгээний 1 албан хаагчид 3,635.3 мян.төгрөгийн цалин хөлс тооцон олгоод байна. 	100
		4. Салбарын болон аймгийн хөгжилд бодит дэмжлэг болохуйц санаачлага, амжилтыг үнэлж аймгийн шагналд тодорхойлох, алдаршуулах, төрийн дээд шагналд уламжлах	Одоогоор шагнагдаагүй.	-
		5. Төрийн албан хаагчийг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэн хууль, журмын дагуу зохих нэмэгдэл, урамшуулал олгох	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмыг ил тод байдлын самбар цахим хуудсанд байршуулсан. Төрийн захиргааны албан хаагчийн ажлыг эхний хагас жилийн байдлаар дүгнэнэ. Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварыг сар бүр үнэлж, 2022 оны 6 сарын 06-ны байдлаар 1,799,5 мян. төгрөг олгосон.	100
3	Төрийн албанд тогтвортой, өндөр үр бүтээмжтэй, идэвхи санаачилгатай ажиллах нөхцөл бүрдүүлэх, албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх.	1. Албан хаагчдад хууль журмын дагуу болон ар гэрт гачигдал, тэмдэглэлт үйл явдал тохиолдсон үед байгууллагын дотоод журамд заасны дагуу тусламж, тэтгэмж үзүүлэх	Байгууллагын дотоод журамд заасны дагуу 2 албан хаагчид газрын даргын тушаалаар тус бүр 5 хоногийн цалинтай чөлөө олгосон.	100
		2. Албан хаагчдын хүүхдийн төрсөн өдрөөр 1	Газрын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д албан хаагчийн хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө	100

		өдрийн цалинтай чөлөө олгох	олгох заалт оруулсан. 2022 оны эхний хагас жилд 4 албан хаагчид чөлөө олгосон.	
		3. Хамт олонч уур амьсгал бүрдүүлэх, идэвхитэй хөдөлгөөн, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх аялал, спорт, уралдаан тэмцээн бусад арга хэмжээ зохион байгуулах	Шинэ жил, ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Орчин цагийн зэвсэгт хүчний ой, эх үрсийн баяр зэргийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлсэн. Чөлөөт цагаар аялалд гарах, спортоор хичээллэх зэргээр 4 арга хэмжээ зохион байгуулсан.	100
		4. Гэр болон галлагаатай байранд амьдардаг албан хаагчдад түлээ нүүрс худалдан авахад хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх.	Хугацаа болоогүй.	-
4	Ажилтан албан хаагчдаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх.	1. Ажилтан, албан хаагчдыг артерийн даралт, чихрийн шижин, элэгний хавдар болон бусад халдварт бус өвчнийг илрүүлэх үзлэгт хамруулах, тодорхой хувийг байгууллагын төсвөөс зарцуулах	2022 оны эхэнд албан хаагчдыг Гэгээн мандарваа уламжлалтыгн эмнэлэгт үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулсан.	100
		2. Албан хаагчдыг 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамруулах.	Төсөв болон бусад нөхцөл байдалтай уялдуулан 4-р улиралд хэрэгжүүлнэ.	-
		3. Албан хаагч өөрөө болон гэр бүлийн гишүүнээ эмчилгээ, оношилгоонд хамруулахаар дээд шатны болон нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлэхээр явахад 7 хүртэл хоногийн цалинтай чөлөө олгох	Тайлант хугацаанд 3 албан хаагч эрүүл мэндийн үзлэг оношлогоонд орохоор байгууллагын удирдлагаас хувийн чөлөө хүссэн бөгөөд нийт 9 өдөрт ногдох 355.8 мян.төгрөгийн олговор олгох шийдвэр гаргасныг хэрэгжилтийг ханган ажилласан.	100

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ,
 ҮР ДҮНГ УРАМШУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

Д/д	Арга хэмжээний тоо	100	90%	Хэрэгжилт				Хувь
				70%	50%	30%	Хугацаа болоогүй	
1	16	13				2	100	

ТАЙЛАН ГАРГАСАН: Ахлах мэргэжилтэн

Б.ГАНДУЛАМ